



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Байгаль орчны газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/16/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:Bulgan@audit.gov.mn">Bulgan@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас:9907-9641 Цахим хаяг: <a href="mailto:Tserenlhamg@audit.gov.mn">Tserenlhamg@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 223

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА  
А.ГАНТӨМӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 онд байгаль орчныг хамгаалах, ногоон технологийг дэмжих, олон улсын сайн туршлага, стандарт бүтээмжийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэх, байгаль орчныг хамгаалах хяналт тавих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол

6328050473

хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэж ажилласан байна.

#### **Бусад асуудал**

Булган аймагт хуш модны самар бэлтгэх хэмжээг ойгоос ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар хуш модны самрын хэмжээг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/706 дугаар тушаалаар улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамаарахгүй Тэшиг сум 270.0 мянган кг, Сэлэнгэ сум 30.0 мянган кг, хамаарахгүй Хутаг-Өндөр сум 47.0 мянган кг, Сэлэнгэ 15.0 мянган кг-аар байхаар баталсан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	34,900.6	86,915.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	546,102.1	626,207.9
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>581,002.7</b>	<b>713,123.7</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	2,462.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	581,002.7	710,660.9
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>581,002.7</b>	<b>713,123.7</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,945,119.4	2,126,832.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,939,492.3	1,997,174.5
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>5,627.1</b>	<b>129,658.2</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(99,480.3)	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(93,853.2)</b>	<b>129,658.2</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	674,855.9	581,002.7
	Тайлант оны үр дүн	(93,853.2)	129,658.2
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>581,002.7</b>	<b>710,660.9</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,871,987.2	1,937,927.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,859,197.5	1,922,185.7
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>12,789.7</b>	<b>15,741.4</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(12,789.7)</b>	<b>(15,741.4)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(0.0)</b>	<b>0.0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>-</b>	<b>1,787,079.3</b>
	Урсгал зардал	-	1,787,079.3
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>-</b>	<b>1,787,079.3</b>
	Улсын төсвөөс санхүүжих	-	1,787,079.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

## Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

### Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгаль орчны газар нь эрхэм зорилгоо “Аймгийнхаа байгалийн баялгийг түүний нөөцийн хэмжээ, даацтай нь нийлүүлэн зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй хадгалж байх, ард иргэдэд өөрсдөө орон нутгийнхаа байгалийн баялгийг ашиглах хамгаалахтай холбогдсон экологийн мэдлэг олгох таатай орчин бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхээр дараах тэргүүлэх чиглэлийг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн чиглэлээр төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах;
- Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглуулах;
- Байгаль орчны холбогдолтой багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр;
- Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх;

Аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих, байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, ногоон технологийг дэмжих, олон улсын сайн туршлага, стандарт бүтээмжийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэх, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргын 2025 оны А/815 дугаар захирамжаар 81.7 хувьтай үнэлүүлэн “хэвийн” үнэлгээ авсан байна.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Авлигын эсрэг хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль тогтоомж, Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Үйл ажиллагаандаа Амьтны тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ойн тухай хууль, Усны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Хог хаягдлын тухай хууль тогтоомжууд, Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,

- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Булган аймагт хуш модны самар бэлтгэх хэмжээг ойгоос ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар хуш модны самрын хэмжээг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/706 дугаар тушаалаар улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамаарахгүй Тэшиг сум 270.0 мянган кг, Сэлэнгэ сум 30.0 мянган кг, хамаарахгүй Хутаг-Өндөр сум 47.0 мянган кг, Сэлэнгэ 15.0 мянган кг-аар байхаар баталсан байна.

#### **Тав. Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 онд байгаль орчныг хамгаалах, ногоон технологийг дэмжих, олон улсын сайн туршлага, стандарт бүтээмжийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэх, байгаль орчныг хамгаалах хяналт тавих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэж ажилласан байна.

#### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

## Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн, 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй байна.

## Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**Илрүүлэлт 1:** Архив албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан хийж ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын албан тоот, тушаал гэх мэт хэвлэмэл болон улсын байцаагчийн үнэт цаасыг бодитоор тоолж, тайланг хариуцсан ажилтнаар гаргуулж хэвших зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

## Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж байгаа эсэхийг хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 189.8 сая төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 189.8 сая төгрөгийн 6 алдааг бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 16.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 7.4 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9.2 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 16.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2.8 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

## Төлбөрийн акт

**Илрүүлэлт 1:** Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар тогтоогдсон 01/131 дугаартай төлбөрийн актыг төсвөөс төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж, зориулалт бусаар зарцуулсан 2.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт 2:** Аймгийн Байгаль хамгаалах сангаас томилолтоор ажиллах хугацаанд цагийн бүртгэлийг үнэн зөв бүртгээгүйгээс хоол унааны нөхөх төлбөрийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нөхөх төлбөрийг зөрүүтэй тооцож, давхардуулан олгосон 0.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**Илрүүлэлт 3:** Жолооч, нярав гэж орон тоог баталсан байхад жолоочид нярвын албан тушаалын албан үүргийг хавсран гүйцэтгүүлж цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль, журам зөрчиж нярвын албан тушаалын албан үүргийг хавсран гүйцэтгэсэн 4.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

## Албан шаардлага

**Илрүүлэлт 1:** Орхон, Сайхан, Хутаг-Өндөр сумын байгаль хамгаалагчийн орон тоог баталсан эрх зүйн шийдвэр байхгүй байхад тус орон тоонд албан хаагчид хавсран гүйцэтгүүлсний нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2029 оны 09 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", Булган аймгийн Засаг даргын 2024 оны А/718 дугаар захирамж "Бүтэц орон тоо батлах тухай" шийдвэртэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль журмыг хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

**Илрүүлэлт 2:** Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй гэх нотлох баримт байхгүй зөвхөн нэр бүхий сумын Засаг даргын албан бичгүүдийг үндэслэн 3 албан хаагчид ээлжийн амралтыг биеэр эдлээгүйн нөхөх төлбөр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй гэх нотлох баримтгүй олгосон зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

**Илрүүлэлт 3:** Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх зүйн шийдвэргүйгээр 1-3 хувиар нэмэгдүүлэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль журмыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг дутуу илэрхийлсэн	1	0.4			1	0.4	1	0.4				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөг илүү зөрүүтэй тайлагнасан.	1	30.4			1	30.4	1	30.4				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулах бичилт хийгээгүй, зардлаар тайлагнасан.	1	142.5			1	142.5	1	142.5				
Ерөнхий журналд цалингийн өглөг дансанд илүү тайлагнасан.	1	4.0			1	4.0	1	4.0				
СУДТ, МГТ-ын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг зардлыг цалингийн картаарх олговол зохих цалингийн дүнгээр дутуу тайлагнасан.	1	0.01			1	0.01	1	0.01				
Шатах тослох материалын 12.5 сая төгрөгийг 6 удаагийн орлого бөөн дүнгээр нь бүртгэж, зарцуулж тайлагнасан.	1	12.5			1	12.5	1	12.5				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>189.8</b>			<b>6</b>	<b>189.8</b>	<b>6</b>	<b>189.8</b>			<b>6</b>	<b>189.8</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга												
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар тогтоогдсон 01/131 дугаартай төлбөрийн актыг төсвөөс төлсөн.	1	2.1	1	2.1								
Аймгийн Байгаль хамгаалах сангаас томилолтоор ажиллах хугацаанд цагийн бүртгэлийг үнэн зөв бүртгээгүйгээс хоол унааны нөхөх төлбөрийг илүү олгосон.	1	0.8	1	0.8								
Жолооч, нярав гэж орон тоог баталсан байхад жолоочид нярвын албан тушаалын албан үүргийг хавсран гүйцэтгүүлж цалин олгосон.	1	4.5	1	4.5								

Орхон, Сайхан, Хутаг-Өндөр сумын байгаль хамгаалагчийн орон тоог баталсан эрх зүйн шийдвэр байхгүй байхад тус орон тоонд албан хаагчид хавсран гүйцэтгүүлсний нэмэгдэл олгосон.	1	1.4		1	1.4						
Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй гэх нотлох баримт байхгүй зөвхөн нэр бүхий сумын Засаг даргын албан бичгүүдийг үндэслэн 3 албан хаагчид ээлжийн амралтыг биеэр эдлээгүйн нөхөх төлбөр олгосон.	1	5.8		1	5.8						
Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх зүйн шийдвэргүйгээр 1-3 хувиар нэмэгдүүлэн олгосон.	1	2.0		1	2.0						
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>16.6</b>	<b>3</b>	<b>7.4</b>	<b>3</b>	<b>9.2</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Архив албан хэрэг хөтлөлтийн хэвлэмэл хуудас болон үнэт цаасны тайлан хийж ажиллаагүй.	1	0							1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>							<b>1</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>							<b>1</b>	<b>0</b>